

# 1. ӨРХ, ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1. Өрх, хүн ам: 2011 оны эцсээр манай аймаг 4519 өрхтэй болж өмнөх оноос 230 өрхөөр буюу 5.4 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 15056 хүн тоологдсон нь өмнөх оноос 548 хүнээр буюу 3.8 хувиар өслөө. Нийт хүн амын 30.8 хувийг 0-15 насны хүүхэд, 63.8 хувийг хөдөлмөрийн насны буюу 16-59 насны хүмүүс, 5.4 хувийг өндөр настнууд буюу 60 ба түүнээс насны хүмүүс эзэлж байна.

Тайлант онд 468 өрхийн 829 хүн шилжин ирж, 362 өрхийн 584 хүн шилжиж явсан байна. Насны бүлгээр нь авч үзвэл 20-29 насны иргэдийн шилжилт хөдөлгөөн зонхилж байна.

Хүн амын ердийн хөдөлгөөний мэдээгээр энэ онд 389 хүүхэд эхээс мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар, 96 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс тус тус өссөн үзүүлэлттэй байлаа.

Бүртгүүлсэн гэр бүл 49 бүртгэгдсэн нь өмнөх оноос 25.6 хувиар, цуцалсан гэр бүл 20 бүртгэгдсэн нь өмнөх оноос 5.3 хувиар тус тус нэмэгдэж, 5 хүүхэд үрчлэгдсэний 2 нь 3 хүртэлх насны, 2 нь 3-6 насны, 1 нь 7-9 насны хүүхдүүд байна.

## Хүн амын тоог сумдаар мэдээлбэл:

Сумд		2010	2011	Өсөлт Бууралт	Хувь
Баянтал	Бүгд	864	931	67	107.7
	Эрэгтэй	439	471	32	107.3
	Эмэгтэй	425	460	35	108.2
Сүмбэр	Бүгд	10697	11102	405	103.8
	Эрэгтэй	5281	5454	173	103.3
	Эмэгтэй	5416	5648	232	104.3
Шивээ- говь	Бүгд	2947	3023	76	102.6
	Эрэгтэй	1500	1543	43	102.9
	Эмэгтэй	1447	1480	33	102.3
Дүн	Бүгд	14508	15056	548	103.8
	Эрэгтэй	7220	7468	248	103.4
	Эмэгтэй	7288	7588	300	104.1

**2011 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог  
насны бүлэглэлээр үзүүлбэл:**

Насны бүтэц	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
0-4.	1721	884	837
5-9.	1297	667	630
10-14.	1342	699	643
15-19	1475	753	722
20-24	1722	866	856
25-29	1465	733	732
30-34	1225	595	630
35-39	1141	549	592
40-44	1004	490	514
45-49	853	410	443
50-54	628	309	319
55-59	379	182	197
60-64	253	105	148
65-69	200	85	115
70-74	161	62	99
75-79	103	42	61
80-84	50	24	26
85-89	30	11	19
90-94	5	2	3
95-99	1	-	1
100+	1	-	1

Насны бүлэглэлээс харахад 70 ба түүнээс дээш настан 351, 80 ба түүнээс дээш настан 87, 90 ба түүнээс дээш настан 7, 100 ба түүнээс дээш настан 1 байна. Аймгийн хамгийн өндөр настан нь Сүмбэр сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт амьдарч байна.

## Өрхийн тоог сумдаар үзүүлбэл:

Сумд	2010	2011	Өсөлт бууралт	Хувь
Баянтал	290	316	26	8.9
Сүмбэр	3065	3244	179	5.8
Шивээговь	934	959	25	2.7
Дүн	4289	4519	230	5.4

Нийт өрхийг байршлаар нь авч үзвэл:

Аймгийн төвд 2710 өрх буюу нийт өрхийн 60.0 хувь

Сумын төвд 1047 өрх буюу нийт өрхийн 23.2 хувь

Хөдөө багт 762 өрх буюу нийт өрхийн 16.8 хувь

**1.2.** Аймгийн хэмжээнд 329 ажлын байр шинээр бий болсон ба эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал:

- Хөдөө аж ахуй -38
  - Уул уурхай олборлох үйлдвэрлэл -17
  - Боловсруулах үйлдвэр -35
  - Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж -5
  - Усны хангамж, бохир ус зайлуулах систем -1
  - Барилга -33
  - Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар -67
  - Зочид буудал зоогийн газар -73
  - Тээвэр агуулахын аж ахуй -21
  - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа -4
  - Төрийн удирдлага, батлан хамгаалах -9
  - Боловсрол -16
  - Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ -2
  - Үйлчилгээний бусад үйл ажиллагаа -8 тус
- тус бий болсон байна.

Шинээр бий болсон ажлын байрны 298 нь байнгын, 31 нь улирлын чанартай байна. Шинэ ажлын байрыг сумдаар нь авч үзвэл:

- Сүмбэр суманд 301 ажлын байр
- Шивээговь суманд 9 ажлын байр
- Баянтал суманд 19 ажлын байр бий болсон байна.

**1.3.** Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээгээр бүтэн өнчин хүүхэд 14 байгаагийн 6 нь эмэгтэй. Хагас өнчин 176 хүүхэд байдгаас 0-6 настай 26, 7-9 настай 20, 10-15 настай 84, 16-18 настай хүүхэд 46 байна. Хагас өнчин хүүхдийн 73 нь буюу 41.5 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 17.6 хувиар буурч, хагас өнчин хүүхэд 13.5 хувиар өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 493 бүртгэгдсэнээс төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 107, бүгдээс эмэгтэй 233 бүртгэгдсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх оноос 21.4 хувиар өссөн мэдээтэй байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 0-15 насны хүүхэд 24, хөдөлмөрийн насны 413, өндөр настан 56 байна.

2010 онд тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй 1 өндөр настан байсан бол энэ онд 2 болж өссөн бөгөөд энэхүү өндөр настангууд нь Сүмбэр, Шивээговь сумдад амьдарч байна.

16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 64, 8 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 39, Өндөр настай ганц бие өрхийн тоо 135 бүртгэгдсэн.

Аймгийн хэмжээнд өрх толгойлсон эмэгтэй 652 амьдарч байгаа нь өмнөх оноос 27.7 хувиар буурчээ .

Үүний: 437 нь буюу 67.0 хувь нь 3 хүртэл хүүхэдтэй

184 нь буюу 28.2 хувь нь 3-5 хүүхэдтэй

31 нь буюу 4.8 хувь нь 6-аас дээш хүүхэдтэй хүмүүс байлаа.

**1.4.** Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн зарим үзүүлэлтүүдийг тайлант оны байдлаар авч үзвэл (Тайлант онд АДТүвшин Төвийн бүсэд 91700 төгрөг байлаа.)

Ядуу өрх 488, өрхийн гишүүд 1971 байгаа нь нийт өрхийн 10.8 хувийг, нийт хүн амын 13.1 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

Нийт ядуу өрхөөс нэн ядуу өрх 222, Өрхийн гишүүд нь 939 байгаа нь нийт ядуу өрхийн 45.5 хувийг, ядуу өрхийн гишүүдийн 47.6 хувийг эзэлж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0.9-4.6 хувиар өссөн үзүүлэлт гарлаа.

Ядуу өрхийн гишүүдийн 23.5 хувь нь боловсролгүй, 15.6 хувь нь ЕБС-д суралцагсад байна. Энэ онд орон гэргүй ядуу өрх 30 бүртгэгдсэний 66.7 хувь нь нэн ядуу өрх байлаа. Аймгийн хэмжээгээр ядуу өрхүүдэд 2.9 сая.төгрөгийн мөнгөн, 13.6 сая төгрөгийн бусад тусламжийг олгосон байна.

#### **1.5. Аймгийн халамжийн сан 2011 онд:**

Халамжийн тэтгэвэрт 298 хүнд 168.4 сая. төг

Нөхцөлт мөнгөн тэтгэмжид 176 хүнд 41.1 сая. төг

Нөхцөлт мөнгөн тусламжид 146 хүнд 14.0 сая.төг

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээ 230 хүнд 6.8 сая.төг

Хүний хөгжил сангийн хишиг хувь олголт 14191 хүнд 3668.4 сая.төг

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 669 хүнд 107.6 сая. төг

Алдар цолтой ахмад настны тэтгэмж 24 хүнд 25.1 сая.төг

Алдарт эхийн одонтой эхчүүдийн тусламж 1171 хүнд 170.1 сая.төг

Ахмад настны хөнгөлт 952 хүнд 48.6 сая.төг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт 199 хүнд 27.1 сая төг

Бусад сангаас 21 хүнд 5.0 сая төгрөг нийт 18077 иргэнд 4282.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

## 2. ХӨДӨӨ АЖ АХУЙ

2.1. Малын тоо: Аймгийн хэмжээгээр 2011 оны эцэст 189.6 мянган мал тоологдсон нь өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өссөн үзүүлэлт гарлаа.

Тэмээ	597	толгой			
Адуу	8580	толгой			
Үхэр	4333	толгой			
Хонь	79022	толгой			
Ямаа	97119	толгойгоор	тус	тус	

тоологдлоо.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Тэмээ	13.7	хувиар	
Адуу	24.1	хувиар	
Үхэр	17.3	хувиар	
Хонь	21.2	хувиар	
Ямаа	26.3	хувиар	тус тус өссөн байна.

Нийт малын дүнд тэмээ 0.3 хувь, адуу 4.5 хувь, үхэр 2.3 хувь, хонь 41.7 хувь, ямаа 51.2 хувийг эзэлж байна.

### 2.2. Малын тоо сумдаар:

	Баянтал	Сүмбэр	Шивээ-говь	ДҮН
Тэмээ	144	391	62	597
Адуу	1724	5936	920	8580
Үхэр	478	3206	649	4333
Хонь	10903	58112	10007	79022
Ямаа	11832	73877	11410	97119
Бүгд	25081	141522	23048	189651
Хээлтэгч	11139	65029	9932	86100
Нийт малд хээлтэгчийн хувь	44.4	45.9	43.1	45.4

Аймгийн хэмжээнд 811 малтай өрхийн 2701 ам бүлийн гишүүд, 526 малчин өрхийн 1826 ам бүлийн гишүүд тоологдсон ба нийт малчид 936, үүнээс эмэгтэй малчид 425 буюу нийт малчдын 45.4 хувийг эзэлж байна. Малчин өрх болон, өрхийн гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн.

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл :

16-34 нас -354 малчин буюу 37.8 хувь

35-59 нас эр ,

35-55 нас эм – 417 малчин буюу 44.6 хувь

55 аас дээш нас эм ,

60 аас дээш нас эр – 165 малчин буюу 17.6 хувийг тус тус эзэлж байна.

### Малын тоо (толгойгоор)

	2010	2011	Хувь	Зөрүү
<b>БҮХ МАЛ</b>				
Толгойн тоогоор	153223	189651	123.8	36428
Тэмээ	525	597	113.7	72
Адуу	6911	8580	124.1	1669
Үхэр	3695	4333	117.3	638
Хонь	65195	79022	121.2	13827
Ямаа	76897	97119	126.3	20222
<b>АМИНЫ МАЛ</b>				
Толгойн тоогоор	150795	187175	124.2	36380
Тэмээ	447	525	117.4	78
Адуу	6894	8571	124.3	1677
Үхэр	3682	4312	117.1	630
Хонь	63260	77013	121.7	13783
Ямаа	76512	96754	126.4	20242

Хувийн малын тоо 187.2 мянган толгойд хүрсэн нь өмнөх жилийнхээс 24.1 хувиар буюу 36.4 мянган толгойгоор, нийт малд хувийн мал 98.7 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.3 хувиар тус тус өссөн байна.

## 2. 3. Малын төллөлт, төл бойжилт:

2011 онд аймгийн хэмжээгээр нийт 67.2 мянган төл бойжуулж авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 24.5 мянган төлөөр буюу 57.3 хувиар илүү бойжилттой байна.

### Бойжсон төлийг төрлөөр нь авч үзвэл:

	2010	2011	Зөрүү	Хувь
Ботго	84	112	28	133.3
Унага	1165	2013	848	172.8
Тугал	1153	1442	289	125.1
Хурга	19982	29740	9758	148.8
Ишиг	20363	34213	13850	168.0
Бүгд	42747	67250	24503	157.3

### Төл бойжилт: /толгойгоор/

		2010	2011
Гарсан төл	Бүгд	47842	67654
	Ботго	93	120
	Унага	1249	2049
	Тугал	1195	1456
	Хурга	21860	29619
	Ишиг	23445	34410
Хорогдсон төл	Бүгд	5095	404
	Ботго	9	8
	Унага	84	36
	Тугал	42	14
	Хурга	1878	149
	Ишиг	3082	197
Бойжсон төл	Бүгд	42747	67250
	Ботго	84	112
	Унага	1165	2013
	Тугал	1153	1442
	Хурга	19982	29740
	Ишиг	20363	34213



Төл бойжилтийн хувь	Бүгд	89.4	99.4
	Ботго	90.3	93.3
	Унага	93.3	98.2
	Тугал	96.5	99.0
	Хурга	91.4	100.4
	Ишиг	86.6	99.4

Хорогдсон төлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл 12.6 дахин буурсан ба нийт хорогдсон төлийн 85.6 хувийг ишиг, хурга эзэлж байна.

**2.4.** Том малын хорогдол: 2011 оны жилийн эцсийн байдлаар 314 том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны том малын хорогдлоос 47.8 дахин буурсан байна.

#### Малын зүй бус хорогдол /толгой/

Он	Бүгд	Үүнээс:				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2005	311	-	7	8	137	159
2006	1020	3	61	66	471	419
2007	79	2	16	12	34	15
2008	6824	23	715	219	2389	3478
2009	7367	1	376	238	2730	4022
2010	15316	6	265	171	5993	8881
2011	314	8	15	8	171	112

#### Малын зүй бус хорогдлыг сумдаар үзүүлбэл:

Сумд	Хорогдсон том мал		Оны эхний малд эзлэх хувь	
	2010	2011	2010	2011
Баянтал	5568	15	20.7	0.1
Сүмбэр	7675	271	6.5	0.2
Шивээговь	2073	28	8.8	0.1
Дүн	15316	314	9.1	0.2

**2.5.** Оны эцэст 86.1 мянган хээлтэгч мал байгаа нь өнгөрсөн оны хээлтэгч малаас 17.6 хувиар буюу 12.9 мянган толгойгоор цөөрчээ.

## Хээлтэгч малыг өмнөх онтой харьцуулбал: /толгой/

Сумд	2010	2011	Зөрүү	Хувь
Баянтал	8541	11139	2598	130.4
Сүмбэр	55109	65029	9920	118.0
Шивээговь	9572	9932	360	103.8
Дүн	73222	86100	12878	117.6

**2.6.** Аймгийн дүнгээр цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 7.3 мянган толгой мал тоологдсон бөгөөд цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн малыг төрлөөр нь ангилбал:

- Тэмээ 43 буюу 0.6 хувь
- Адуу 15 буюу 0.2 хувь
- Үхэр 44 буюу 0.6 хувь
- Хонь 2008 буюу 27.4 хувь
- Ямаа 5227 буюу 72.1 хувь

Аймгийн хэмжээнд “Сүмбэр” болон “Сүмбэр-Монгол” эрлийз хонь 954 толгой тоологдсон нь нийт эрлийз , нутгийн шилмэл омгийн малын 13 хувийг ,нийт эрлийз хонины 74.5 хувийг эзэлж байна.

**2.7.** 2011 онд малтай өрх 811 түүний ам бүлийн гишүүд 2701 бүртгэгдсэн бөгөөд энэ онд манай аймгаас 23 мянгат малчин төрлөө. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 53.3 хувиар нэмэгдсэн байна.

Үүнд:

Сүмбэр сумын мянгат малчин 16  
Баянтал сумын мянгат малчин 5  
Шивээговь сумын мянгат малчин 2

Мянгат малчдаас хамгийн их малтай нь Сүмбэр сумын 4 дүгээр багийн иргэн Д.Эрдэнэ-Очир /2022 толгой мал/, хамгийн их тэмээтэй нь Сүмбэр сумын 5 дугаар багийн иргэн Г.Майнбаяр, хамгийн их адуутай нь Баянтал сумын 2 дугаар багийн иргэн Л.Батнасан, хамгийн их үхэртэй нь Сүмбэр сумын 2 дугаар багийн иргэн М.Батсайхан, хамгийн их хоньтой нь Сүмбэр сумын 5 дугаар багийн

иргэн Д.Зоригтсайхан, хамгийн их ямаатай нь Сүмбэр сумын 4 дүгээр багийн иргэн Д.Эрдэнэ-Очир нар байлаа.

**2.8.** Аймгийн хэмжээгээр 6.2 га талбайгаас 73.1 тн төмс, 17.5 га талбайгаас 114.6 тн хүнсний ногоо, 24.0 га талбайгаас 206.9 тонн тэжээлийн ургамал хурааж авсан нь өмнөх оны мөн үеэс тариалсан талбайн хэмжээ буурч, гас авах хураасан ургац өссөн үзүүлэлт гарлаа. Мөн 1366.7 тн өвс, 139.7 тн гар тэжээл бэлтгэсэн байна.

**2.9.** ХАА-н тэжээвэр амьтдын тооллогын дүнгээс үзэхэд аймгийн дүнгээр гахай, шувуу, туулай тэжээдэг өрх 35 тоологдлоо.

Нийт 90 гахай үүнээс:

үндсэн эх	39
хээлтүүлэгч	9
бусад	42

Нийт 205 шувуу үүнээс:

үндсэн эх	182
хээлтүүлэгч	20
бусад	3

Нийт 6 туулай үүнээс:

үндсэн эх	3
хээлтүүлэгч	3
бусад	0

Өмнөх оны мөн үеэс гахай, шувууны тоо нэмэгдэж, туулайн тоо буурчээ.

**2.10. Жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг 2010, 2011 оны байдлаар харьцуулж танилцуулбал:**

дд	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011
1	Сан бүрдэлт	сая.төг	650	1122.0
2	Хүлээж авсан төсөл	тоо	82	129
3	Дэмжигдсэн төсөл	тоо	48	83
4	Зээл олгосон төсөл	тоо	38	65
5	Олгогдсон зээлийн хэмжээ	сая.төг	650	1122.0
6	Шинээр бий болсон ажлын байр	тоо	93	174

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн дагуу Монгол улсын засгийн газрын 2011 оны 134-р тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” тухай журам батлагдан тус журмын дагуу сумдад “Сум хөгжүүлэх сан” байгуулж Сүмбэр суманд 265 сая, Шивээговь, Баянтал суманд тус бүр 50 сая төгрөг, нийт 365 сая төгрөгийн сан бүрдүүлж, дээрх сангаас 40 иргэн аж ахуй нэгжид 365 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож шинээр 100 ажлын байр бий болсон байна.

### 3. АЖ ҮЙЛДВЭР

#### 3.1 . Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээг ШОНУ, Ус-Ду, Тохижилт-Сүмбэр, Талын илч, Илчлэг-шивээ зэрэг томоохон аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг билээ. Эдгээр аж ахуйн нэгж байгууллага нь 2011 оны жилийн эцсийн байдлаар 25022.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 24648.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулжээ.

Үүнээс: Шивээ-Овоо Хувьцаат Компани 1586.3 мянган тонн нүүрс гаргаж, 23695.2 сая төгрөгийн нүүрс борлуулсан байна.

ШОНУ	Хэмжих нэгж	2011
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	мян.тн	1578.0
Нүүрс олзворлолт /биет хэмжээ/	мян.тн	1586.3
Бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	23695.2
Нийт бүтээгдэхүүн	сая.төг	24069.9

Дээрх үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Нүүрс борлуулалт 93.1 мян.тн-оор

Нүүрс олзворлолт 228.8 мян.тн-оор тус тус буурсан байна.

Тус уурхайн нүүрс борлуулалтын үнэ 17116 /НӨАТ тооцогдсон/ төгрөг болсон байна.

#### 3.2 Дэд бүтэц

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах станц ТӨХК-ий Чойр дахь салбар 110 кВ ба түүнээс дээш өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах, хэрэглэгчдийг найдвартай тасралтгүй эрчим хүчээр хангах ажлыг эрхэлж байна.

Харин Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ий Чойр дахь салбар болон УБТЗ-ын харьяа Эрчим хүч, ус хангамжийн 2-р анги нь 110 кВ-оос доошхи цахилгаан эрчим хүчний дотоод хуваарилалтын сүлжээг

хариуцан ажиллаж 2011 онд нийт 21201.8 мян кВт/ц цахилгаан эрчим хүч хүлээн авч, 21924.8 мян кВт/ц цахилгаан эрчим хүч боловсруулан түгээгээд байна.

Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир татан зайлуулах чиглэлээр Ус Ду, Талын Илч, Илчлэг Шивээ ОНӨҮГ-ууд болон Төмөр замын Барилга орон сууцны анги үйл ажиллагаа явуулж байна. 2011 онд ус дулааны байгууллагууд нь нийт 45000 м<sup>3</sup> хэрэглээний халуун ус үйлдвэрлэн, 459090 м<sup>3</sup> цэвэр ус түгээж, 389768 м<sup>3</sup> бохир татан зайлуулсан байна.

#### 4. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР

**4.1** Тээвэр, авто замын газар, Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын алба нь орон нутаг дахь тээвэр зохицуулалтын бүхий л үйл ажиллагааг эрхэлж байна. Аймгийн хэмжээнд нийт ГСА 1379 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Тээврийн хэрэгслийн оношлогоог 2011 онд дуустлах хугацаанд явуулж, улсын дугаар харгалзахгүйгээр нийт 2339 тээврийн хэрэгслийг оношложээ.

Мөн аймгийн төв доторхи нийтийн тээвэрт “Говийн зууч” ХХК Айсо маркийн автобусаар, аймаг доторхи такси үйлчилгээнд “Сансарын хүлэг”, “Бодьзам” ХХК-ууд 60 гаруй таксигаар 24 цагийн туршид тээврийн үйлчилгээгээ үзүүлж хэвшлээ.

Тээвэр, авто замын газрын мэдээг харуулбал:

/өссөн дүнгээр/

	Хэмжих нэгж	2011
Зорчигч эргэлт	мян.хүн.км	2300.4
Тээсэн зорчигч	мян.хүн	10.8
Тээврийн орлого	мян.төг	8648.4
Ажиллагчдын тоо	хүн	8

**4.2** Холбооны газар, Мэдээлэл холбооны сүлжээ компани, Төмөр замын дохиолол холбооны анги, Шуудан үйлчилгээний газар, үүрэн телефоны Мобиком, Скайтел, Юнител, Жи Мобайл корпорациуд манай аймагт үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг .

Мэдээлэл холбооны сүлжээ компани нь холбооны шилэн кабель, мэдээлэл, КаТВ, интернет, АТС-ын суурин утасны дамжуулах сүлжээний ажлыг эрхэлж байна.

Шуудан үйлчилгээний газар нь айл өрх, албан байгууллагуудад бичиг захидал, илгээмж хүргэх зэрэг үйлчилгээ үзүүлж байна.

Аймгийн Холбооны газрын мэдээгээр холбоо ашиглалтын орлого 155.7 сая төгрөг болсон ба үүнээс: Хүн амаас орох орлого 62.3 сая төгрөгт хүрсэн байна. 2011 онд 2628 цахилгаан мэдээ дамжуулсан нь өмнөх оны мөн үеэс өссөн байна. Аймгийн хэмжээгээр КТВ суваг 1324 байна. Телефон цэгийн тоо 395, үүнээс айл өрхөд 217 цэг ашиглагдаж байна.

**4.3** Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын мэдээгээр манай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 554.2 мян.га байдаг бөгөөд нийт талбайн:

68.0 хувийг Сүмбэр сум

16.5 хувийг Баянтал сум

15.5 хувийг Шивээговь сум эзэлж байна.

Нийт газрын :

97.8 хувийг Хөдөө аж ахуйн газар

1.0 хувийг хот, тосгон, суурин газар

0.7 хувийг Зам шугам сүлжээний газар

0.3 Усан сангийн газар

0.2 хувийг Улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлдэг .

Тайлант жилд : Нийт газрын 1.1 хувьд хохирол учирсан ба нийт газрын 0.3 хувьд хамгаалах арга хэмжээ авчээ.

Газрын төлбөр төлөлт, ноогдуулалтанд 42.8 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 21.6 хувиар өссөн үзүүлэлт гарлаа.

2011 оны жилийн эцсийн байдлаар 3235 иргэнд 507.2 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүй өмчлүүлсэн байна.

## 5. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА ORGANIZATION

Аймгийн татварын хэлтсийн бүртгэлээр 2011 онд 264 байгууллага үйл ажиллагаа явуулсан байна.

Дээрх аж ахуйн нэгж байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл:

▪ ХК	2
▪ ХХК	99
▪ ББН	6
▪ ЗБН	10
▪ Хоршоо	7
▪ Хадгаламж зээлийн хоршоо	1
▪ ОНӨҮГ	5
▪ Салбар байгууллага	47
▪ Төлөөлөгчийн газар	2
▪ Төсөвт байгууллага	49
▪ Шашны байгууллага	4
▪ Сан	3
▪ Олон нийтийн байгууллага	13
▪ Төрийн бус байгууллага	16

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал аж ахуй нэгж байгууллага 14.8 хувиар нэмэгдсэн байна.

2011 оны эхний хагас жилд зохион байгуулагдсан Аж Ахуй Нэгж Байгууллагын Улсын тооллогоор 201 аж ахуйн нэгж бүртгэгдсэн байна.



## 6. ТӨСӨВ BUDGET

2011 онд төвлөрсөн төсвийн орлого 3310.0 сая төгрөг, зарлага санхүүжилт 10659.2 сая төгрөг болов.

### Аймгийн төсвийн орлого, зарлага

сая.төг

	2010	2011
Төсвийн		
Орлого	3207.8	3310.0
Зарлага	8161.9	10659.2
Орлого зарлагын зөрүү /+, -/	-4954.1	-7349.2

**6.1.** 2011 онд төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 102.5 хувьтай байна.

### Төсвийн орлого

сая.төг

	2011 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Төвлөрсөн төсвийн орлого	3228.9	3310.0
Орон нутгийн орлого	2894.2	2951.9
Үүнээс: Татварын орлого	1259.1	1358.9
Татварын бус орлого	197.7	204.0
Хөрөнгийн орлого	67.0	77.8
Тусламжийн орлого	551.6	551.6

## 6.2 . Төсвийн зарлага, санхүүжилт

сая.төг

	2011 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага	10823.4	10659.2
Цалин хөлс	5090.7	5110.2
Шимтгэл	495.1	491.8
Бараа үйлчилгээний бусад	3524.2	3597.9
Татаас ба шилжүүлэг	434.4	420.2
Хөрөнгийн зардал	1278.9	1038.9

Нийт зарлага санхүүжилтэд 10823.4 сая төгрөг төлөвлөснөөс 10659.2 сая төгрөгийг зарлага санхүүжилтэд зарцуулснаар 1.5 хувийн хэмнэлт гарсан байна.

Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр:

- авлагын үлдэгдэл 6.4 сая төгрөг
- өглөгийн үлдэгдэл 8.8 сая төгрөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал авлага 41.3 хувиар буурч, өглөг 7.6 дахин өссөн үзүүлэлт гарчээ.

## 6.3 Банк санхүү, даатгал

Банк санхүү

Говьсүмбэр аймагт ХААН, ХАС, Хадгаламж банкуудын салбар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тайлант онд банкуудын явуулсан үйл ажиллагааг танилцуулъя.

Банкуудын эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэлээр үзүүлбэл:

/өссөн дүнгээр/

Д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	ДҮН
1	Салбар, үйлчилгээний цэгийн тоо	тоо	11
2	Цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид	хүн	4373
3	Нийт ажиллагсад	хүн	73
4	Үүнээс : Зээлийн эдийн засагч	хүн	16
5	Хадгаламж эзэмшигчдийн тоо	хүн	7095
6	Хадгаламжийн хэмжээ	сая.төг	3857.7
7	Хадгаламжийн дундаж хүү /сарын/	хувь	3.5
8	Хадгаламжийн бүтээгдэхүүний тоо	тоо	34
9	Зээлийн бүтээгдэхүүний тоо	тоо	39
10	Зээлийн дундаж хүү	хувь	1.5
11	Зээл авсан: ААНБ	тоо	23
12	Иргэд	хүн	3536
13	Үүнээс : Малчид	хүн	154
14	Зээл олголтын хэмжээ: ААНБ	сая.төг	175.6
15	Иргэд	сая.төг	9178.2
16	Үүнээс : Малчид	сая.төг	274.3
17	Зээлийн эргэн төлөлт	хувь	98.7
18	Харилцахын тоо	тоо	28544
19	Харилцахын дүн	сая.төг	3063.4
20	Карт эзэмшигчдийн тоо	хүн	15175
21	Карт эзэмшигчдэд олгодог хүүгийн хэлбэр	хувь	3.4
22	АТМ-ын тоо	тоо	4

Дээрх үзүүлэлтээс харахад нийт зээл авсан иргэдийн 4.3 хувийг, зээлийн нийт хэмжээний 2.9 хувийг малчдад олгосон зээл эзэлж байна.

Даатгал

Говьсүмбэр аймаг дахь Монгол даатгал ХХК-ны салбар нь ард иргэдийн болон үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагын эд хөрөнгө, иргэдийн амь нас , эрүүл мэнд зэрэг 11 төрлийн даатгалын бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлдэг байна

Даатгалын бүтээгдэхүүний төрлийг хүснэгтээр харуулбал:  
/сая.төг өссөн дүнгээр /

Дд	Даатгалын бүтээгдэхүүний төрөл	2011 онд	
		Орлого	Олгосон нөхөн төлбөр
1	Тээврийн хэрэгслийн даатгал	61.8	57.5
2	Жолоочийн харицлагын даатгал	13.9	3.5
3	Эд хөрөнгийн даатгал	9.5	0.9
4	Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	10.6	7.9
5	Гэнэтийн ослын даатгал	19.6	2.8
6	Хүүхдийн гэнэтийн ослын даатгал	2.2	1.4
7	Хурдан морь унаач хүүхдийн даатгал	-	-
8	Мэргэжлийн хариуцлагын даатгал	0.7	-
9	Гэр хашаа байшингийн даатгал	1.7	0.0
10	Барьцаа хөрөнгийн даатгал	-	-
11	Иргэний цалингийн зээлийн даатгал	-	-

2011 онд даатгалын бүтээгдэхүүний орлого 120.0 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 47.6 хувиар, олгосон нөхөн төлбөр 73.9 сая төгрөг буюу өнгөрсөн оны мөн үеэс 2.6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

## 7. НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭ

### 7.1 Нийтийн аж ахуй үйлчилгээ

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2010	2011
Усан хангамж	Цэвэр усны өргөх станц	тоо	2	2
	Усан сан	тоо	2	1
	Ундны ус түгээх байр	тоо	7	8
	Ундны усны гүний худаг	тоо	40	44
	Ундны ус тээврийн машин	тоо	1	1
	Түгээсэн ундны усны жилийн нийт хэмжээ	мян.м <sup>3</sup>	15	19.5
	Зөөврийн ундны ус хэрэглэдэг өрх	тоо	2152	2485
Хог хаягдал зайлуулалт	Хог устгалын цэг	тоо	26	19
	Хог тээврийн машин	тоо	6	6
	Тээвэрлэсэн хуурай хог хаягдлын хэмжээ	мян.м <sup>3</sup>	22.9	39.4
	Үүнээс: хүн амаас/ орон сууц болон гэр хорооллоос/	мян.м <sup>3</sup>	13.7	25.7

2011 оны байдлаар ундны ус түгээх байрын тоо 14.3 хувиар, түгээсэн ундны усны жилийн нийт хэмжээ 30 хувиар, зөөврийн ундны ус хэрэглэдэг өрхийн тоо 15.5 хувиар, тээвэрлэсэн хуурай хог хаягдлын хэмжээ 72.1 хувиар өссөн байна.

## 8. ГЭМТ ХЭРЭГ

**8.1** 2011 онд аймгийн хэмжээнд 119 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй ижил байна. Гэмт хэргээс учирсан хохирлын хэмжээ 149.7 сая төгрөгт хүрч нь өмнөх оны мөн үеэс 42.2 хувиар буурчээ.

### Аймгийн хэмжээнд гарсан гэмт хэрэг

дд		2010 он	2011 он
1	Гарсан гэмт хэрэг: Бүгд	119	119
2	Хүн амины хэрэг	3	2
3	Хулгайн хэрэг	20	30
4	Бусад	96	87
5	Гэмт хэрэг үйлдэгчид:Бүгд	134	123
6	Эрүүлжүүлэгдсэн хүн	1180	946
7	Баривчлагдсан хүн	58	83
8	Гэмт хэргээс учирсан хохирол	259.2	149.7
9	/сая.төг/ Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төгрөг/	185	101.2

Жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүний 19.8 хувиар буурч, баривчлагдсан хүний тоо 43.1 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.

## 9. БОЛОВСРОЛ

**9.1** 2011-2012 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд 6 цэцэрлэгт 1120 хүүхэд хамрагдан хүмүүжиж байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 33 бүлэг ажиллаж байгаагаас цэцэрлэгийн сургалтын яслийн бүлэг 2, бага бүлэг 5, дунд бүлэг 5, ахлах бүлэг 7, бэлтгэл бүлэг 4, холимог бүлэг 2, хувилбарт сургалтын ээлжийн бүлэг 4, нүүдлийн бүлэг 4 ажиллаж байна.

**9.2** 2011-2012 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 5 сургууль хичээллэж түүнд 2920 хүүхэд суралцаж байгаагаас бага боловсрол олгоход 1454 суралцагч, суурь

боловсрол олгоход 961 суралцагч, бүрэн дунд боловсрол олгоход 493 суралцагч сурч байна./Өдрөөр суралцагчид/ ЕБС-д бүтэн өнчин 13, хөгжлийн бэрхшээлтэй 2 сурагч байна.

ЕБС-д 168 үндсэн багш ажиллаж байгаа ба нэг багшид ногдох суралцагчийн тоо 17 байна.Өмнөх оны мөн үетэй харьцуулбал: Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн тоо 17.3 хувиар , Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 0.5 хувиар , багш нарын тоо 0.6 хувиар , нэг багшид ногдох суралцагч 0.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

## 10. ЭРҮҮЛ МЭНД ,ЭМ ТАРИА

**10.1** Аймгийн хэмжээний эрүүл мэндийн үзүүлэлтийг жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн газрын мэдээгээр авч үзвэл:

Нийт төрсөн эх 352 байна.

Үүнээс : Амьд төрсөн хүүхэд 354

Гэрийн төрөлт 1

### Эрүүл мэндийн газрын зарим үндсэн үзүүлэлтүүд

дд	Үзүүлэлт	Үзлэгийн тоо	Нийт үзлэгт эзлэх хувь
1	Нийт үзлэг	105962	100.0
2	Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг	36853	34.8
3	Өвчний учир амбулаторын үзлэг	46211	43.6
4	Идэвхитэй хяналтын үзлэг	12404	11.7
5	Гэрийн үзлэг	9651	9.1
6	Гэрийн дуудлага	843	0.8

Нийт өвчлөлийг авч үзвэл:

Халдварт бус өвчлөл 12050

Осол гэмтлийн өвчлөл 680

Халдварт өвчлөл 290 тохиолдол гарчээ.

Нийт өвчлөл өмнөх оны мөн үетэй харьцуулбал буурсан үзүүлэлт гарлаа.

Нийт нас баралт 78 ,

- Хорт хавдрын 17
- Осол гэмтлийн 16
- Бусад 45

**10.2** Аймгийн хэмжээнд 5 эмийн сан ажиллаж байгаа бөгөөд тайлант онд 280.1 сая төгрөгийн эм тариа борлуулсны дотор хүн амд 213.5 сая төгрөгийн эм тариа борлуулсан байна.

Үүнээс: Аймгийн төв эмийн сан 101.3 сая төгрөгийн эм тариа татан авч, 102.0 сая төгрөгийн борлуулалт хийснээс хүн амд 65.0 сая төгрөгийн эм тариаг борлуулсан байна. Оны эцэст 23.5 сая төгрөгийн эм тариа бусад зүйлийн нөөцтэй байна.



# **ХЭЛТЭС , АЛБАДЫН ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ОНЦЛОГ АЖЛУУДААС:**

## **СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**Тайлант онд манай хэлтэс улсын хэмжээний томоохон тооллого, судалгааг орон нутагт амжилттай зохион байгуулсан байна.**

**Үүнд:**

**Аж ахуйн нэгжийн тооллого:** Засгийн газрын 2011 оны 61 тоот тогтоолыг үндэслэн аж ахуйн нэгжийн тооллогыг орон нутагт зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/98 тоот захирамж, сумдын Засаг дарга нарын А/36 ,39, 35 тоот захирамжуудыг батлуулж , шат шатандаа ажлын төлөвлөгөө гарган орон нутагт тооллогын ажлыг цаг хугацаанд нь , чанартай сайн зохион байгууллаа. Тооллогоор 201 аж ахуйн нэгж бүртгэгдсэний 24.9 хувь буюу 50 нь төсөвт , 60.2 хувь буюу 121 нь аж ахуйн нэгж, 14.9 хувь буюу 30 нь төрийн бус байгууллага байлаа.

**Нөөц ашиглалтын хүснэгт зохиох судалгаа:**

НАХ судалгааны 1 дүгээр шатны судалгаанд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгж болох 11 байгууллага хамрагдсан нь аймгийн нийт аж ахуйн нэгжийн 4.1 хувийг эзэлж байна. /201 аж ахуйн нэгж/. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийг хариуцлагын хэлбэрээр нь ангилбал:ХК 1, ХХК1,ОНӨҮГ 2 , Төсөвт байгууллага 7.

НАХ-ын түүвэр судалгааны 2 дугаар шатны судалгаа манай аймгийн 12 нэгжид хийгдсэнийг хариуцлагын хэлбэрээр нь ангилбал: ОНӨҮГазар1, хоршоо 1, ХХК 7, ЗБН 1, ТББ 2 хамрагдаж байна.

## **Малын ашиг шимийн гарц, хөдөө аж ахуйн орлого, зардлын түүвэр судалгаа:**

Орон нутагт тооллого судалгааны ажлуудыг цаг хугацаанд нь бүрэн хамралттайгаар зохион байгуулах зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Энэхүү судалгаанд 14 өрх хамрагдсан бөгөөд сүү, ноос ноолуурын гарцын хэмжээг бүртгэж өглөө.

**Ажиллах хүчний судалгаа:** Манай аймгийн хувьд тайлант жилийн байдлаар сар бүр нэг нэгжид нийт 144 өрх Ажиллах хүчний судалгаанд хамрагдсан бөгөөд судалгааг амжилттай зохион байгуулж, шивэлтийг тухай бүр хийж хугацаанд нь дамжууллаа.

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЦЭРГИЙН ШТАБ**

Монгол Улсын Засгийн газар, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын тушаал заавар, тогтоол удирдамжууд Аймгийн засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ болон захиалгат бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааг эрхэм болгон ажиллаж байна.

Зэвсэгт хүчний баяр, Халх голын ялалтын ойн хүрээнд батлан хамгаалах хууль сурталчлах зорилгоор цэрэгжүүлсэн байгууллагуудын дунд цэрэг спортын уралдаан тэмцээнийг явуулсан.

2011 онд цэргийн албаа хааж ирсэн дайчдыг аймгийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд урилгаар оруулж өөрсдийн сонирхсон мэргэжлээр нь суралцуулж эхэллээ.

## ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА II ТӨСЛИЙН НЭГЖ

2011 онд Тогтвортой амьжиргаа II төслийн хүрээнд нийт 282.2 сая төгрөгийн өртөгтэй 42 төслийг баталж худалдан авах ажиллагааны үр дүнгээр 6.3 сая төгрөг хэмнэж 275.9 сая төгрөгийн өртөгтэй 42 төслийг хэрэгжүүлж байна.

хувь

Үзүүлэлт	Төслийн тоо	Нийт санхүүжилт /сая.төг/	Нийт ашиг хүртэгсэд
Олон нийтийн санаачилгын бүрэлдэхүүн хэсэг	11	96802.4	8766
Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийн удирдлагын бүрэлдэхүүн хэсэг	31	179081.3	12759

Дээрх төслүүдэд орон нутгийн төсвөөс 5-8 хувийн, иргэд олон нийтээс 0-10 хувийн, Тогтвортой төслөөс 70-90 хувийн хөрөнгийг оруулсан байна.

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөө 3638.0 сая төгрөгөөр, зарлага 3551.9 сая төгрөгөөр батлагдаж, орлогын төлөвлөгөө 105.3 хувиар давж, нийгмийн даатгалын сангуудын зарлага 97.7 хувийн биелэлттэй гарлаа.

2011 онд нийт 18662 хүнд 2598.2 сая төгрөгийн тэтгэвэр, 1629 хүнд 364.5 сая төгрөгийн тэтгэмж, давхардсан тоогоор 16884 хүний эмнэлэгийн тусламж үйлчилгээний зардалд 466.6 сая төгрөг, 6067 хүнд 31.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмийн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олголоо.

Монгол улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу хүний хөгжил сангаас хишиг хувь хүртэх хэлбэрээр эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлүүлсэн 1691 даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл 12.7 сая төгрөгийг хүний хөгжил сангаас олгосон байна.

## **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Барилга, хот байгуулалтын салбарын бодлогын хэрэгжилтийг хангах үндэсний хөтөлбөрүүд, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллан аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай нийт 3294,5 гаруй сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажлуудад захиалагчийн эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллаа.

Манай байгууллага нь улсын болон орон нутгийн төсөв, гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилга угсралт, их засвар, инженерийн шугам сүлжээний нийт 23 объектод гэрээний дагуу захиалагчийг төлөөлж ажилласан байна.

### **ШУУДАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Говьсүмбэр аймгийн шуудан үйлчилгээний газар нь 21 аймаг, 350 гаруй сумдын салбар болон Улаанбаатар хотын шуудангийн 30-аад салбарт шуудангийн 20 гаруй нэр төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Улс хот хоорондын шуудан, аймгийн төв сум хооронд 7 хоногт 1-5 удаа хүргэхээс гадна дэлхийн 190 шахам улс оронтой, түүний дотор шуудангийн хамгийн шуурхай хэлбэр буюу Буухиа шууданг 19 оронтой солилцож байна. 2011 онд албан бичиг 2088-ыг явуулж , 2560-ыг хүлээн авч, илгээлт 69-ыг явуулж, 300-ыг хүлээн авч, хувь хүн, албан газарт 1255 бичиг захидал гардуулж, 27 сая төгрөгийн давхардсан тоогоор 3051 төрлийн хэвлэл захиалга авч ялган боловсруулж тараасан байна.

## **БОЛОВСРОЛ СОЁЛЫН ГАЗРЫН**

Төрийн өмчийн 5, төрийн бус өмчийн 2 цэцэрлэгийн үндсэн сургалтанд 982 хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамралт 100 хувьд хүрлээ. Хүүхдийн цэцэрлэгт нийт 113 ажиллагсад ажиллаж байгаагаас 36 үндсэн багш байгаа ба мэргэжилтэй багшийн хангалт 88,8 хувьтай байна.

Ерөнхий боловсролын 5 сургуулийн 102 бүлэгт 2920 суралцагч өдрөөр суралцаж байгаа ба албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 93 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 100 хувь, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 95 хувьд хүрсэн байна. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 99.7 хувьтай байгаа ба мэргэжил дээшлүүлэх хөрвөх сургалтанд нийт 5 багш хамрагдаж байна.

2011 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсрол соёлын салбарт барилга угсралтад 1.526.0 сая төгрөг, их засварт 130.0 сая төгрөг, тавилга тоног төхөөрөмжийн зардалд 298.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдэж Сүмбэр сумын 1,2, 5 дугаар сургууль үдийн цайны тоног төхөөрөмжөөр 100 хувь хангагдсан байна. Аймгийн хэмжээнд бүх сургууль, цэцэрлэгүүдэд ажиллах сурах таатай орчин бүрдсэн.

Статистикийн хэлтэс  
2012-01-18

---

Хаяг: govisumbergsa@yahoo.com

Утас:23222, 23017

Вэб: [www.statis.mn/portal](http://www.statis.mn/portal)